

ОНОЛ, УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

К. МАРКС МОНГОЛЫН ТУХАЙ

Н. Ишжамц, ШУА-ийн сурвалжлагч
гишүүн, М. Пагма

Марксизм-ленинизмын нийтлэг ерөнхий онолын үндэслэл, аргазүйн зарчим бол БНМАУ-ын социалист бүтээн байгуулалтын их үйл хэргийг гэрэлтүүлэн гийгүүлж байна.

Урьдын цагт хоцрогдмол хагас колони байсан Монголын нийгмийг 1921 оны ардын хувьсгал мандмагц Лениний заасан капиталист биш зам дээр гарган хувьсгалт ёсоор өөрчилж хөгжүүлэхэд марксист-ленинист сургаал нь үзэл санааны хүчирхэг зэвсэг болж өгсөн юм. Монголын ард түмэн, түүний тэргүүн хувьсгалт манлай МАХН нь гагцхүү марксч-ленинч үзлээр удирдлага болгон зөвлөлүүдийн орны ахан дүүсэг тусламж дэмжлэгийн ачаар гялалзсан амжилтанд хүрээд тэр нь хөгжиж байгаа орнуудын ард түмнийг урамшуулан зоригжуулж байна.

Түүхийн шинжлэх ухаан, дэлхий нийтийн нийгмийн сэтгэлгээний бусад бүх салбарт Дорнодахины улс орнууд, түүний дотор мөн Монголын тухай марксизм-ленинизмийн үндэс суурийг тавигсадын үлдээсэн арвин их өв уламжлал бий. Нийт дорно дахин, нүүдлийн малчин улс түмэн болоод Монгол улсын түүхэн хөгжлийн талаар Маркс, Энгельс, Лениний дурдан заасан зүйлс нь манай орны түүх, амьдрал хөгжил, түүний ирээдүйн төлвийг нэн гүн гүнзгийгээр ухааран ойлгоход зарчмын чухал ач холбогдолтой юм.

Маркс, Энгельс нарын «Германы үзэл суртал» гэх зэрэг хамтын бүтээл, Марксын зохиосон «Капиталист үйлдвэрлэлийн өмнөх урьдчилсан хэлбэрүүд», мөн түүний үйлдсэн «Л. Г. Морганы «Эртний нийгэм» хэмээх номын товчлол» болон бусад зохиолд нь анхны хүй нэгдлийн байгуулалт нийгмүүд, нүүдэлчин малчин улс түмэн, аймаг-овгийн байгууллын тухай гүн утга агуулсан суут санаанууд байдаг нь эрт, дундат үеийн Монголын түүхтэй бас шууд холбогддог юм. Монголын аж ахуй, амьдрал байдал, шашин шүтлэгийн тухай Маркс, Энгельс нар «Германы үзэл суртал» (М., 1933) зохиолдоо дурдсан нь: «Жинхэнэ монголчууд бол дээрхи тэнгэрлиг огторгуйг шүтэн бишрэхээсээ даамай илүүгээр дэргэдэх хонь малаа эрхэмлэн адуулдаг» (148-р тал) гэсэн байна. Энэ нь мал сүрэг бол монголчуудын үйлдвэрлэлийн гол хэрэгслийн нэг, үндсэн баялаг нь байсан бөгөөд тэдний амьдралд алив сүсэг бишрэлээс нэн чухал үүрэг гүйцэтгэдэг байсан үнэн учрыг илэрхийлжээ. Марксын бичсэн «Капиталист үйлдвэрлэлийн өмнөх урьдчилсан хэлбэрүүд» (М, 1940) зохиолд «Нүүдлийн малчин нь газар нутагтайгаа шуудаар биш, харин хамт олон, аймаг овгоор дамжуулан харьцаж ханддаг» (26-р тал), өөрөөр хэлбэл хүй нэгдлийн байгууллын үед нүүдэлчдийн дунд газар нь хамтын эзэмшилд үлдэж, хувийн өмч болоогүй байв гэсэн байна. Тус зохиолд Маркс бас дорнодахины нүүдлийн малчин улс түмний тухай өгүүлэхдээ: «Дорно зүгийн бэлчээрийн малчин аймгуудад-бүх малчин аймаг нь анх нүүдлийн байсан бөгөөд,—газар нутаг нь байгалийн бусад нөхцлийн нэгэн адил өөрийн хязгаарлалгүй язгуур байд-

лаар оногдож байв. Жишээлбэл. Азийн хээр тал, өндөрлөг хээрийн бүсэд түүнийг бэлчээр болгох зэргээр ашигладаг, тэгээд түүн дээр нь мал сүрэг бэлчин идээшилж, тэр сүргээр малчин ардууд өөрсдөө амьдардаг. Тэдгээр малчид газрыг өөрсдийн өмч мэт үзэн хандаж харьцах боловч тийм өмчийг хэзээ ч тодорхойлон тогтоодоггүй» (24—,25-р тал) гэсэн байна. Мөн зохиолд нүүдэлчдийн нийгэмд хувийн өмч, баян ядуугийн ялгаа, боол эзэмших ба хамжлагат ёсон үүсэх тухай Маркс үгүүлэхдээ: «Энд үнэн хэрэг дээрээ газар биш, харин гагцхүү мал сүрэг л өөрийншигдөн эзэмшигдэж, нөхөгдөн үйлдвэрлэгдэж байдаг, гэвч газрыг буусан зогсоол бүр дээр түр хамтран ашигладаг... дайн байлдаан бол өмчийн зүйлийг хамгаалж үлдээх болоод мөн түүнийг олж эзэмшихийн төлөө аяндаа үүсэн бүрэлдсэн тэдгээр хамтлаг тус бүрийн хамгийн балар эртний маягийн хөдөлмөр үйлсийн нэг байв... Тэхдээ хэрэв газрын хамт түүний органик хамааралт зүйлийн хувьд нь хүнийг өөрийг нь бас байлдан дагуулж байсан бол түүнийг чухамдаа үйлдвэрлэл явуулах нэг нөхцөл болгож эзэгнэн авч байсан хэрэг мөч бөгөөд тийм замаар боол эзэмших ёс ба хамжлагын хамаарал үүсч,.. бүх хамтлагийн суурь болж удал төдөлгүй тэдгээр хамтлагийн анхан түрүүчийн хэлбэр байдлыг гаж ондоо болгож, хувирган өөрчилдөг» (24—25-р тал) гэсэн байна.

Тиймхүү Маркс хүй нэгдлийн байгууллын үеийн нүүдэлчдийн нийгэмд хувийн өмч байсангүй, гагцхүү нийтийн өмч, хамтын хөдөлмөр дагнаж байсныг тодруулж томъёолоод зогссонгүй, бас боол эзэмших ёс үүсч, анхны анги давхраа ялгаран, эцгийн эрхт ёс ноёлсон түрүү феодалын харилцаа тогтох үйл явц, түүний зүй тогтлыг ерөнхийд нь гайхамшигтай нарийн ажигласан байна. Түүний хийсэн ажиглалт, дүн шинжилгээнүүд нь зөвлөлт, монголын болон бусад орны эрдэмтдийн онолын шинжилгээний ба түүхийн судалгаагаар бүрэн нотлогдож, улам баяжин хөгжиж байна.

Эртний дорнодахин, дундад зууны Ази болоод шинэ үеийн Энэтхэг, Хятад, Иран, Араб, Турк, Монгол зэрэг орны ангит нийгэм, төр улсуудын мөн чанар, шинж төрхийн хувьд Маркс XIX зууны 50-иад оны үеэр «азийн үйлдвэрлэлийн арга», «дорнодахины эзэрхэг засаг» гэх мэт ойлголт гарган томъёолж байв. Тухайн үед Маркс «Сахарын цөлөөс эхлэн Араб, Перс, Энэтхэг, Татараар дамжин Азийн хамгийн өндөр уулст тултал үргэлжилдэг их говийн бүслэл»¹ дэх газрын хөрс уур амьсгалын онцлог шинж байдлын учир тэнд газар дээр хувийн өмч ноёлон зонхилох болсонгүй, харин нийгмийн үндсэн нэгж нь хөдөө тосгоны хөршийн хүй нэгдэл байж, дорнодахины эзэрхэг засаг түүний төрийн хэлбэр болсон юм гэж үзэж байжээ. Маркс Ази болон нийт дорнодахинд төр улс нь бүх газар нутгийн дээр өмчтөн эзэн болсоор ирсэн бөгөөд түүний хамт тэнд бас «хувийн журмаар, түүнчлэн мөн хөршийн хүйгээр газрыг эзэмших ба эзлэх ёс аль аль нь зэрэгцэн оршиж байв» (Капитал, т. III, с. 804) гэж үзэж байжээ.

Гэвч Марксын сүүлчийн бүтээлүүдэд «Азийн үйлдвэрлэлийн арга», «дорнодахины эзэрхэг засгийн» тухай баримтлал ялангуяа нэр томъёоны хувьд үндсэндээ орхигдож, хүн нийгмийн хөгжлийн эрэмбэ дараалсан таван хэлбэршил, тухайлбал анхны хүй нэгдэл, боол эзэмших ёс феодализм, капитализм ба коммунизм гэдэг ойлголтын эхний гурвын дотор зохих ёсоор хуваагдан багтаж тодорхойлогдох болсон байна. Марксист-ленинист түүхийн шинжлэх ухааны хөгжлийн явцад Монгол зэрэг дорнодахины бусад олонхи улс оронд феодалын газрын өмчлөл

¹ К. Маркс и Ф. Энгельс, Избранные письма. М., 1953, с. 74—75.

байсан явдал нотлогдсон юм. Тэхдээ тэнд хөршийн хүй удтал хадгалаглан үлдсэн, газрыг хөршийн хүйгээр эзэмшиж, гишүүд нь түүний бас хувийн журмаар ч эдлэн хэрэглэж байсан, газрын дээд өмчтөн эзэн нь төр улс байсан гэдгийг илтгэн харуулсан Марксын онол-аргазүйн үндэслэл хэвээр үлдэж, шинжилгээ судалгаанд бүтээлчээр хэрэглэгдэн байна.

Марксын гар дээр Монголын түүхийн тийм олон эх сурвалж байгаагүй, түүний бүтээл нь тусгайлан Монголын судлалд зориулагдаж байгаагүй боловч XIII—XIV зууны Монголын түүхийн талаар Маркс бас ихээхэн чухал ажиглалт хийж үлдээсэн байна. Түүний үлдээсэн түүхийн он дараалсан тэмдэглэлүүдийн архивын V ботид тухайн үеийн Монголын түүхийн бүхэл бүтэн товчлолууд байх бөгөөд тэдгээрийн дотор Чингис-хаан ба Монголын феодалын байлдан дагууллын асуудалд Маркс тодорхой дүн шинжилгээ хийсэн байдаг юм. Маркс Монголын түүхийн асуудалд хөрөнгөтний эрдэмтдийн басамжлан үздэгээс чанар чиглэлийн эрс ялгаатай хандаж, шинэ алхам хийсэн байна. Тухайлбал, XIII зууны Монгол орон, Монголын нийгмийг Маркс феодалын эрхт иргэний ба шашны нийтлэг цааз хууль бүхий анхны ангит нийгмийн төр улсын зохион байгуулалттай байв гэж үзсэн нь үнэн бөгөөд зөв юм.² Монгол зэрэг зарим нүүдэлчин улс түмний дунд үе үе «хүн ам дээр эдийн засгийн илүүдэл дарамт» үзэгддэг гэж Маркс үгүүлэн, нүүдэлчдийн аян дайны материаллаг бодит шалтгааны тухай асуудлыг анх хөндөн тавьсан боловч булаан эзлэх дээрмийн шинж чанарыг нь огтхон ч үгүйсгээгүй юм. Маркс харин бүхийлэн зүйлийн дээрмийн харгис дайныг, түүний дотор мөн Бат, Хубилай, Хүлэгү нарын зэрэг байлдан дагуулагчдын аян дайныг эрс буруушааж байв. Маркс дэлхий нийтийн түүхээс товчлон түүвэрлэсэн «он цагийн тэмдэглэл»-дээ Чингис хааны аян дайны эвдэн сүйтгэгч, бүдүүлэг шинжийг цохон заасан байна.³ «XVIII зууны нууц дипломат харилцаа» зохиолдоо Маркс Монголын феодалууд эзлэгдсэн орнуудыг хэрхэн ноёрхож байсан тухай дурдсан нь: «Энэхүү талхидал нь түүнд өртөн хэлмэгдсэн ард түмнийг дарангуйлаад зогсоогүй, харин санаа сэтгэлийг нь хүртэл доромжлон хатингартуулж байв. Монгол-татарууд байнгын айлган сурдүүлэх дэглэм тогтоосон байв. Үгүйрүүлэн хоосруулж, үй олноор нь алан хядах явдал ердийн үзэгдэл болжээ»⁴ гэсэн байна. Монголын түүхчид бид ч гэсэн одоо дэлхий нийтийн түүх болон мөн манай орны өнгөрсөн үеийн амьдрал хөгжилд Монголын феодалын байлдан дагуулал харгис үүрэг гүйцэтгэсэн болохыг зохих ёсоор зааж тэмдэглэдэг юм. Монгол улсын дотоод амьдрал хөгжил, гадаад харилцааны асуудлыг Маркс авч үзэхдээ Монгол нь зөвхөн зэргэлдээх Хятадтай харилцаж байсангүй, бас түрэг угсааны улс түмэн, Иран зэрэг бусад орнуудтай нэн нягт харилцаа холбоотой байсныг анхаарч ажигласан байна. Маркс 1857 онд цэрэг дайны түүхийн зарим асуудлын талаар Энгельсэд үгүүлсэн зүйлдээ: «...Азийн цэрэг дайны тогтолцоо анх персүүдийн дунд үүсэн гарсан байдлаараа, дараагаар нь бас янз байдлаа ихэд сүрхий хувиргасан хэлбэрээр бусад зүйлийн зэрэгцээ Монгол Түрэгүүдийн дунд байсаар байна»⁵ гэжээ.

Эцэст нь цохон тэмдэглэвэл зохих нэг чухал зүйл бол Маркс, Энгельс нөр хөгжмөл капиталист орнуудад социалист хувьсгал ялсны да-

² Архив Маркса и Энгельса. т. V М.. 1938, с. 220

³ Архив Маркса и Энгельса. т V с. 221

⁴ K. Marx, *Sekret Diplomatic History of Eighteenth century*, London, 1899, 78.

⁵ K. Маркс Ф. Энгельс, От 25 сентября 1857 г. К. Маркс и Ф. Энгельс, Соч. т. 29, с. 154.

раа буурай хоцрогдсон орнууд ч гэсэн социализмд дэвшин хөгжих боломж олох тухай асуудлыг анх тавьсан явдал юм. Вера Засуличэд илгээх зорилгоор 1870-аад оны үест Марксын бичсэн захидлын анхны ноорог дотор дурдсан зүйлийг үзвэл: «...Орос оронд нөхцөл байдал онцгой улирч ирсний ачаар улс үндэстэн даяар оршин үлдээд байгаа хөдөөгийн хөршийн хүй нэгдэл нь...түүний (тухайлбал капитализмын— Н. И) аймшигт бүх гамшигийг туулж өнгөрөөлгүй... анхны хүй нэгдлийн шинж төрхөөсөө аажмаар чөлөөлөгдөн, хамтын үйлдвэрлэлийн элемент болж шууд хөгжиж болно»⁶ гэсэн байна. 1882 онд Энгельсээс Карл Каутскийд илгээсэн захидалдаа хэрэв тэргүүний хөгжилтэй орнуудад социалист хувьсгал ялбал «Тэр нь тийм их аварга хүчин, тийм сайхан үлгэр дууриал болох учир заримдаг иргэншилт орнууд өөрсдөө аяндаа түүний хойноос даган тэмүүлэх болно. Тэгэхэд тэдгээр орон нь бас социалист байгуулалтанд хүртлээ нийгэм, улс төрийн ямар шат үеүдийг дамжин өнгөрүүлэх хэрэгтэй болох тухайд гэвэл бид зөвхөн нэлээд хуудам таамналыг л дэвшүүлж чадах байна гэж би бодох юм»⁷ гэсэн байна. Энэ бүхний үндсэн дээр Ленин капиталист биш хөгжлийн замын тухай бүхэл бүтэн онол боловсруулан гаргасан нь БНМАУ-д ба Зөвлөлтийн холбооны болон автономит бүгд найрамдах улсуудад нэгэнт хэрэгжин биелээд байгаа билээ.

Капиталист биш хөгжлийн зам социалист чиг баримжаанд хөгжиж байгаа нэлээд улс орон шилжээд улам олон улс түмэн чухам тийм зам, тийм чиг баримжааг үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшилд хүрч, оюун санааны талаар бүрэн чөлөөлөгдөхийн шалгарсан арга хэрэгсэл мөн гэж сонгож авсаар байна.

К. МАРКС О МОНГОЛИИ

Мировая общественная мысль и историческая наука располагают богатим научно-теоретическим наследием основоположников марксизма-ленинизма относительно стран Востока и, в частности, Монголии. Высказывания Маркса, Энгельса, Ленина о кочевых народах и монгольском государстве имеют принципиально важное значение для правильного понимания истории, жизни, культуры и перспективы дальнейшего развития нашей страны.

В «Немецкой идеологии», «Формах, предшествующих капиталистическому производству» и других работах содержатся теоретические положения о пастбище, как основном условии существования кочевого скотоводства, и стаде-одного из главных средств производства и богатства кочевников.

Важное значение имеет анализ Марксом исторического процесса разложения первобытно-общинного строя, формирования рабнефеодальных отношений среди кочевников и социально-экономической структуры кочевого общества.

В «Хронологических выписках» Маркса мы находим конспективное изложение истории возникновения Монгольского феодального государ-

⁶ К. Маркс и Ф. Энгельс, Соч, т. 19. с 401.

⁷ Мөн тэнд, т. 35. с 298

ства и империи монголов. При этом отрицательно характеризуются завоевательные походы Чингис-хана и господство монгольских завоевателей в других странах.

В отдельных работах Маркс высказывает мысль о том, что в «Татарии» или Монголии верховным собственником земли являлось государство, хотя там существовало как частное, так и общинное владение и пользование землей. Это положение нашло подтверждение в более поздних исследованиях советских и монгольских ученых.

Касаясь истории взаимоотношений Монголии с другими странами, Маркс рассматривает ее в связи не столько с соседним Китаем, сколько с тюрками, персами и другими народами.

Принципиальное значение для современного развития монгольского народа имеет впервые выдвинутое Марксом и Энгельсом гениальное теоретическое положение о возможности перехода отсталых стран к социализму, «не переходя через все его (т. е. капитализма-Н. И.) ужасные перипетии».

Это положение основоположников научного коммунизма, которое получило дальнейшее развитие у В. И. Ленина доказано революционной практикой монгольского народа и рядом других стран мира.